



ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2012/04

Улаанбаатар хот  
2012 он



## ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Мал аж ахуйн салбар	2
2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	3
3. Аж үйлдвэрийн салбар	6
4. Цаг агаар	12

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

## 1. МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Улсын хэмжээнд 2011 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 15.7 сая хээлтэгч малын 10.4 сая хээлтэгч буюу 66.3 хувь нь 2012 оны эхний 4 сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 72.7 хувь, эм ямааны 69.5 хувь, ингэний 33.1 хувь, үнээний 30.9 хувь, гүүний 20.5 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.9 хувь буюу 10310.0 мян.толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1133.6 мянга буюу 12.4 хувиар их байна.

Унага бойжилт 98.2 хувь, тугал 98.4 хувь, ботго 98.9 хувь, хурга 99.1 хувь, ишиг 98.7 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.4-1.3 пунктээр өссөн байна.

Том малын зүй бус хорогдол 2012 оны эхний 4 сард улсын хэмжээнд 194.8 мян. толгойд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 167.1 мян.толгой буюу 46.2 хувиар буурсан байна. Том малын зүй бус хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 9.5 мянга, үхэр 18.0 мянга, тэмээ 0.3 мянга, хонь 76.3 мянга, ямаа 90.7 мянга байна. Нийт хорогдлын 39.2 хувийг хонь, 46.6 хувийг ямаа эзэлж байна.

### Мал төллөлт (жил бүрийн эхний 4 сарын байдлаар)

Эх малын төрөл	Төллөсөн хээлтэгч, мян.толгой			Төллөлтийн хувь		
	2010 <sup>1-4</sup>	2011 <sup>1-4</sup>	2012 <sup>1-4</sup>	2010 <sup>1-4</sup>	2011 <sup>1-4</sup>	2012 <sup>1-4</sup>
<b>Бүгд</b>	<b>7012.5</b>	<b>9363.7</b>	<b>10408.2</b>	<b>36.9</b>	<b>60.3</b>	<b>66.3</b>
Гүү	53.5	85.2	131.4	8.2	14.4	20.5
Үнээ	163.6	189.2	298.8	16.0	21.0	30.9
Ингэ	21.0	25.4	31.8	23.4	28.0	33.1
Эм хонь	3939.1	4745.0	5172.7	45.4	66.9	72.7
Эм ямаа	2835.3	4324.9	4773.3	33.1	63.1	69.5

### Төл бойжилт (жил бүрийн эхний 4 сарын байдлаар)

Төлийн төрөл	Бойжуулсан төл, мян.толгой			Бойжилтын хувь		
	2010 <sup>1-4</sup>	2011 <sup>1-4</sup>	2012 <sup>1-4</sup>	2010 <sup>1-4</sup>	2011 <sup>1-4</sup>	2012 <sup>1-4</sup>
<b>Бүгд</b>	<b>5104.2</b>	<b>9176.4</b>	<b>10310.0</b>	<b>72.6</b>	<b>97.7</b>	<b>98.9</b>
Унага	46.9	83.3	129.4	87.6	97.8	98.2
Тугал	140.8	185.0	296.2	86.0	97.8	98.4
Ботго	20.0	25.0	31.5	95.3	98.4	98.9
Хурга	2913.6	4647.1	5125.6	73.8	97.8	99.1
Ишиг	1983.0	4236.0	4727.4	69.8	97.7	98.7

**Зүй бусаар хорогдсон том мал  
(жил бүрийн эхний 4 сарын байдлаар)**

Малын төрөл	Хорогдсон том мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2010 <sup>1-4</sup>	2011 <sup>1-4</sup>	2012 <sup>1-4</sup>	2010 <sup>1-4</sup>	2011 <sup>1-4</sup>	2012 <sup>1-4</sup>
<b>Бүгд</b>	<b>8142.3</b>	<b>361.9</b>	<b>194.8</b>	<b>18.5</b>	<b>1.1</b>	<b>0.5</b>
Адуу	269.6	13.2	9.5	12.1	0.7	0.5
Үхэр	458.8	30.0	18.0	17.7	1.4	0.8
Тэмээ	6.4	0.6	0.3	2.3	0.2	0.1
Хонь	3337.5	156.8	76.3	17.3	1.1	0.5
Ямаа	4070.0	161.2	90.7	20.7	1.2	0.6

**2. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ**

**Хонины нэхий, ямааны арьсны зах зээлийн дундаж үнэ, төг**

Аймаг, нийслэл	Хонины /ноостой/ нэхий, ширхэг		Ямааны /ноолууртай/ арьс, ширхэг	
	2011.IV	2012.IV	2011.IV	2012.IV
<b>Баруун бүс</b>				
Баян-Өлгий	6500	5000	21000	10000
Говь-Алтай	7000	-	20000	12000
Завхан	6000	10000	18000	10000
Увс	4000	11000	-	10000
Ховд	6000	12000	17000	15000
<b>Хангайн бүс</b>				
Архангай	5000	8000	-	-
Баянхонгор	5000	10000	17000	15000
Булган	4500	8000	-	19000
Орхон	5000	7000	12500	-
Өвөрхангай	6000	7000	-	-
Хөвсгөл	5000	6000	15000	15000
<b>Төвийн бүс</b>				
Говьсүмбэр	5000	10000	18000	-
Дархан-Уул	6000	9000	12000	-
Дорноговь	5000	8000	-	-
Дундговь	6000	10300	-	25300
Өмнөговь	5000	8000	-	-
Сэлэнгэ	5000	7000	15000	-
Төв	7000	12000	18000	24000



Зүүн бүс				
Дорнод	5500	9300	-	-
Сүхбаатар	4000	6500	-	-
Хэнтий	7000	10000	-	-
Улаанбаатар				
Улаанбаатар	6500	7000	-	15000

Үхрийн ширний зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Үхрийн шир, ширхэг			
	2 м-ээс доош урттай		2 м-ээс дээш урттай	
	2011.IV	2012.IV	2011.IV	2012.IV
Баруун бүс				
Баян-Өлгий	10000	12500	-	-
Говь-Алтай	10000	17000	12000	26000
Завхан	12000	25000	18000	28000
Увс	9000	23000	12000	25000
Ховд	-	-	12000	22000
Хангайн бүс				
Архангай	10000	24000	18000	38000
Баянхонгор	13000	25000	-	28000
Булган	11000	25000	20000	32000
Орхон	14000	26000	20500	35000
Өвөрхангай	-	25000	17000	30000
Хөвсгөл	15000	25000	18000	-
Төвийн бүс				
Говьсүмбэр	-	15000	-	30000
Дархан-Уул	10000	25000	23000	30000
Дорноговь	12000	-	-	-
Дундговь	-	15300	-	20300
Сэлэнгэ	13000	20000	24000	30000
Төв	15000	35000	25500	40000
Зүүн бүс				
Дорнод	10500	18700	18500	28000
Сүхбаатар	11000	25000	20500	30000
Хэнтий	15000	28000	-	-
Улаанбаатар				
Улаанбаатар	17000	30000	28000	42000

**Адууны ширний зах зээлийн дундаж үнэ, төг**

Аймаг, нийслэл	Адууны шир, ширхэг		Аймаг, нийслэл	Адууны шир, ширхэг	
	2011.IV	2012.IV		2011.IV	2012.IV
<b>Баруун бүс</b>			<b>Төвийн бүс</b>		
Баян-Өлгий	21500	20000	Говьсүмбэр	-	-
Говь-Алтай	20000	28700	Дархан-Уул	24000	28000
Завхан	20000	30000	Дорноговь	24000	-
Увс	-	20000	Дундговь	20500	29000
Ховд	16000	20000	Өмнөговь	20000	20000
<b>Хангайн бүс</b>			Сэлэнгэ	20000	25000
Архангай	20000	26000	Төв	23500	35000
Баянхонгор	-	35000	<b>Зүүн бүс</b>		
Булган	20000	25000	Дорнод	21000	30000
Орхон	28000	30000	Сүхбаатар	22500	25000
Өвөрхангай	20000	35000	Хэнтий	26000	30000
Хөвсгөл	20000	25000	<b>Улаанбаатар</b>		
			Улаанбаатар	28000	35000

**Ямааны ноолуурын зах зээлийн дундаж үнэ, төг**

Аймаг, нийслэл	Ямааны ноолуур, кг			
	Цагаан		Бор	
	2011.IV	2012.IV	2011.IV	2012.IV
<b>Баруун бүс</b>				
Баян-Өлгий	65000	35000	65000	35000
Говь-Алтай	65500	42000	65500	42000
Завхан	71500	42300	71500	43000
Увс	68000	43000	-	42000
Ховд	65000	40000	65000	-
<b>Хангайн бүс</b>				
Архангай	70000	48000	70000	48000
Баянхонгор	68000	45000	68000	40000
Булган	-	48500	65000	51500
Орхон	65000	49000	65000	50000
Өвөрхангай	69500	47000	69500	47000
Хөвсгөл	71000	53000	72500	53000



Төвийн бүс				
Говьсүмбэр	61000	45000	-	-
Дархан-Уул	65000	45000	65000	45000
Дорноговь	60000	46000	60000	46000
Дундговь	67000	42300	67000	-
Өмнөговь	67000	42000	67000	-
Сэлэнгэ	63000	45000	63000	40000
Төв	64500	45000	64500	45000
Зүүн бүс				
Дорнод	60000	39700	60000	39700
Сүхбаатар	61000	44000	55000	44000
Хэнтий	60000	40000	50000	-
Улаанбаатар				
Улаанбаатар	68000	43000	50000	43000

### 3.АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний 4 сард 646.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 61.7 тэрбум төг буюу 10.6 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний 4 сард 1615.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 219.2 тэрбум төг буюу 15.7 хувиар өссөн.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 4 сард оны үнээр 1783.1 тэрбум төг болж, үүний 1174.2 тэрбум төг буюу 65.8 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

#### Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 <sup>IV</sup>	2012 <sup>IV</sup>	2011 <sup>I-IV</sup>	2012 <sup>I-IV</sup>	$\frac{2012^{I-IV}}{2011^{I-IV}}$ (%)
<b>Аж үйлдвэрлийн нийт бүтээгдэхүүн, 2005 оны зэрэгцүүлэх үнээр</b>	<b>161467.0</b>	<b>185465.3</b>	<b>584319.4</b>	<b>646061.5</b>	<b>110.6</b>
<b>Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн</b>	<b>47408.1</b>	<b>56649.6</b>	<b>151974.3</b>	<b>174273.8</b>	<b>114.7</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	25326.6	24519.4	91370.8	100331.9	109.8



Тамхи үйлдвэрлэл	2476.1	2930.8	5397.0	5162.7	95.7
Нэхмэлийн үйлдвэрлэл	9314.0	9163.7	22509.2	21995.0	97.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	493.6	526.4	2399.5	1826.1	76.1
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	28.0	72.5	108.7	368.3	338.7
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	163.0	311.5	668.4	805.3	120.5
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	223.9	603.8	680.8	1371.3	201.4
Тавилга үйлдвэрлэл, бусад	73.9	52.0	325.6	233.0	71.5

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, сая төг**

<i>Аж үйлдвэрийн салбар</i>	<i>2011<sup>IV</sup></i>	<i>2012<sup>IV</sup></i>	<i>2011<sup>I-IV</sup></i>	<i>2012<sup>I-IV</sup></i>	<i>Үүнээс: гадаадад</i>
<b>Аж үйлдвэр, бүгд</b>	<b>431999.4</b>	<b>533454.0</b>	<b>1460745.3</b>	<b>1783098.4</b>	<b>1174159.1</b>
<b>Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн</b>	<b>91288.4</b>	<b>189191.6</b>	<b>287065.2</b>	<b>524744.1</b>	<b>196655.8</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	44973.9	47889.4	172767.9	217017.2	2235.2
Тамхи үйлдвэрлэл	3700.0	3667.7	12100.0	12992.9	-
Нэхмэлийн үйлдвэрлэл	13618.0	19464.1	34371.9	39170.6	20712.4
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	797.1	846.7	3130.3	3048.1	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	53.4	69.6	206.8	348.4	-
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	630.1	1038.6	2508.5	3106.6	-
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	755.3	1285.5	3116.8	3964.5	-
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	196.5	350.5	410.1	625.4	1.9






Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 <sup>IV</sup>	2012 <sup>IV</sup>	2011 <sup>I-IV</sup>	2012 <sup>I-IV</sup>	$\frac{2012^{I-IV}}{2011^{I-IV}} \%$
Хивс	мян.м <sup>2</sup>	63.1	76.6	257.1	312.8	121.7
Сүлжмэл эдлэл	мян.ш	54.7	59.6	204.3	193.1	94.5
Самнасан ноолуур	тн	94.6	64.6	128.2	83.5	65.1
Эсгий	мян.м	20.2	11.9	39.9	96.8	242.6
Тэмээний ноосон хөнжил	мян.м	1.9	-	10.3	2.2	21.4
Эсгий гутал	мян.хос	3.1	2.5	12.6	9.8	77.8
Нэхий дээл	ш	645	4	5315	2008	37.8
Савхин гутал, ботинк	мян.хос	0.4	0.8	1.8	4.3	243.7
Барилгын модон хаалга, цонх	м <sup>2</sup>	558.0	369.2	2119.1	1288.4	60.8
Барилгын шалны банз	м <sup>3</sup>	40.0	110.0	148.0	451.5	305.1
Зүсмэл материал	м <sup>3</sup>	425.0	428.0	1737.7	1952.8	112.4
Дэвтэр	мян.ш	410.0	485.3	1788.8	2476.8	138.5
Ариун цэврийн цаас	мян.ш	315.4	891.0	634.0	1589.7	250.7
Бичгийн цаас	тн	27.1	12.8	99.9	51.2	51.3
Сонин	сая.х.д.х	3.3	4.0	12.3	15.7	127.5
Ном	сая.х.д.х	3.0	4.3	12.9	16.6	128.4
Вакуум цонх, хаалга	м <sup>2</sup>	639.5	537.5	1131.6	1182.9	104.5
Цемент	мян.тн	23.9	41.1	89.3	56.8	63.6
Бетон зуурмаг	м <sup>3</sup>	7289.8	1776.5	7661.3	3700.6	48.3

**Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл**

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 <sup>IV</sup>	2012 <sup>IV</sup>	2011 <sup>I-IV</sup>	2012 <sup>I-IV</sup>	$\frac{2012^{I-IV}}{2011^{I-IV}} \%$
Үхрийн мах	тн	2.4	7.0	185.9	451.7	243.0
Хонины мах	тн	-	3.8	233.9	413.7	176.9
Адууны мах	тн	0.8	-	55.9	16.8	30.1
Ямааны мах	тн	-	-	59.7	299.5	501.7
Гахайн мах	тн	1.0	1.8	7.1	6.2	87.3
Өлөн гэдэс	мян.гогцоо	80.3	85.9	312.5	421.9	135.0
Хиамны зүйл	тн	161.5	169.6	645.9	612.0	94.8
Боловсруулсан шингэн сүү	мян.л	1859.8	2424.1	7461.2	8923.0	119.6
Тараг	мян.л	910.2	1130.0	2648.3	2469.0	93.2
Цөцгий, цөцгийн тос	тн	66.3	129.8	318.7	535.8	168.1
Аарц, бяслаг	тн	0.1	50.1	22.3	85.3	382.5
Дээд гурил	тн	624.5	89.0	6999.8	3978.8	56.8
Нэгдүгээр гурил	тн	6006.9	1832.0	25817.0	15898.2	61.6
Хоёрдугаар гурил	тн	1468.8	2339.5	3903.7	4596.7	117.8
Нарийн боов	тн	1021.5	1032.4	3873.7	4288.9	110.7
Бялуу	тн	25.8	84.9	115.2	239.8	208.2
Чихэр	тн	6.7	5.2	34.1	29.8	87.4
Талх	тн	1911.0	1964.1	6769.1	7926.7	117.1
Гоймон	тн	63.9	174.7	525.2	443.5	84.4
Спирт	мян.л	261.1	456.9	1391.4	1630.0	117.1
Архи	мян.л	2017.5	1665.8	8757.9	8913.9	101.8
Дарс	мян.л	8.0	10.8	36.9	32.6	88.3
Шар айраг	мян.л	5099.9	5481.6	17503.8	20887.1	119.3
Цэвэр ус	мян.л	1561.9	3491.5	6254.6	9610.3	153.7
Амтат ус, ундаа	мян.л	7631.6	7267.4	17157.5	20741.6	120.9
Жүүс	мян.л	6773.6	5391.3	14409.0	19500.4	135.3



### Экспортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 <sup>I-IV</sup>	2012 <sup>I-IV</sup>	$\frac{2012^{I-IV}}{2011^{I-IV}} \%$
Адууны мах	т	91.8	250.1	272.6
Малын дайвар бүтээгдэхүүн	т	243.0	941.9	387.5
Шеврет	сая дм <sup>2</sup>	115.5	74.7	64.7
Шевро	сая дм <sup>2</sup>	66.8	28.5	42.7
Адууны шир	мян.ш	118.1	67.4	57.1
Хонины самнаагүй ноос	т	3609.9	959.9	25.6
Бохир ноолуур	т	637.6	619.9	97.2
Самнасан ноолуур	т	48.9	101.7	207.9
Свитер, пуловер, джемпер, жилет болон сүлжмэл гадуур цамц	мян.ш	8.8	4.6	52.7
Оёмол дотуур хувцас	мян.ш	4.4	0.3	7.1

### Импортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 <sup>I-IV</sup>	2012 <sup>I-IV</sup>	$\frac{2012^{I-IV}}{2011^{I-IV}} \%$
Өндөг	мян.ш	19869.6	24285.2	122.2
Төмс	т	1475.5	1167.0	79.1
Сонгино, сармис	т	4337.5	4341.0	100.1
Алим, лийр	т	2316.4	951.0	41.1
Ногоон цай	т	816.4	662.1	81.1
Цагаан будаа	т	2712.4	4091.9	150.9
Шар будаа	т	670.1	477.0	71.2
Гурил	мян.т	20.3	23.9	117.4
Ургамлын тос	т	942.5	1983.2	210.4
Элсэн чихэр	т	13138.5	11407.0	86.8
Хатуу чихэр	т	1724.9	1618.5	93.8
Согтууруулах биш ундаа	мян.л	2508.9	3500.2	139.5
Согтууруулах ундаа	мян.л	3553.2	6170.1	173.7
Үүнээс: Шар айраг	мян.л	3326.1	5947.8	178.8
Янжуур	сая.ш	581.1	677.9	116.7

#### 4.ЦАГ АГААР

### 2012 оны 6 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ \*\*

#### УУР АМЬСГАЛЫН ТОЙМ


6 дугаар сарын агаарын температурын дундаж нь Ховдын зүүн, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар 20-25, Баян-Өлгийн баруун, Завхан, Хөвсгөл, Архангайн ихэнх нутаг, Говь-Алтайн баруун өмнө ба зүүн хойд, Баянхонгор, Өвөрхангайн хойд хэсгээр 10-14, бусад нутгаар 15-19 градус дулаан байдаг боловч зарим жил энэ утгаас нилээд хазайдаг. Тухайлбал, сүүлийн жилүүдийн байдлаар 1994, 1997 онд төв, говь, зүүн зүгийн нутгаар олон жилийн дунджаас 1-2 градусаар, 2000-2002, 2004, 2007 онд ихэнх нутгаар 2-5 градусаар дулаан болж, үнэмлэхүй их температур уулархаг нутгаар 23-28, бусад нутгаар 33-38 градус хүрч халж байсан бол 1987, 1990 онд олон жилийн дунджаас 1-2 градусаар хүйтэрч үнэмлэхүй бага температур говийн нутгаар 3-8 градус дулаан, уулархаг нутгаар 3-8 градус хүйтэн, бусад нутгаар 1 градус дулаанаас 4 градус хүйтэрч байжээ. Цочир хүйтрэл сарын аль ч үед ажиглагддаг.

Энэ сард олон жилийн дунджаар Их нууруудын хотгор, говийн ихэнх нутгаар 9-29, төвийн нутгийн ихэнх хэсэг, зүүн зүгийн нутгийн баруун хойд хэсгээр 50-70, бусад нутгаар 21-49 мм бороо ордог боловч 1991, 1993, 1996, 2004 онд говийн нутгаар, 1994, 2008 онд ихэнх нутгаар олон жилийн дунджаас 1-3 дахин их бороо орсон бол 1987, 1995, 1998-2000 онд дунджаас бага бороо орсон байна.

Дуу цахилгаан жил бүр 4-8, зарим жил 10-14 удаа ажиглагддаг. Салхины хурд 15 м/с-ээс их болох тохиолдол жил бүр 1-3, зарим жилд 7-9 удаа ажиглагддаг. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан салхины үнэмлэхүй их хурдаас дурдвал, 1991 онд говийн нутгаар, 1995 онд баруун зүгийн нутгийн баруун, говийн нутгийн зүүн хэсгээр түр зуур 28-36 м/с хүрч хүчтэй шороон шуурга шуурч байжээ.

#### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

**Баруун зүгийн нутаг.** The western region. Агаарын температурын сарын дундаж нь нутгийн хойд хагаст 11-16 градус, өмнөд хагаст 15-20 градус дулаан буюу Баян-Өлгий, Завханы ихэнх нутаг, Ховдын өмнөд, Увс, Баянхонгорын хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас 1.5 градусаар дулаан байна ([3 дугаар зураг](#)).





Сарын эхэн болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр сэрүүсч Алтай, Хангайн уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 8-13 градус, Алтайн өвөр говиор шөнөдөө 6-11 градус, өдөртөө 18-23 градус, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус дулаан, хөрсний гадарга дээр сулхан цочир хүйтэрнэ, өдөртөө 13-18 градус дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхээр Алтай, Хангайн уулархаг нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 18-23 градус, Их нууруудын хотгор, Олон нууруудын хөндий, Алтайн өвөр говиор шөнөдөө 14-19 градус, өдөртөө 30-35 градус, бусад нутгаар шөнөдөө 9-14 градус, өдөртөө 23-28 градус дулаан байна. Бусад хугацаанд Алтай, Хангайн уулархаг нутгаар шөнөдөө 0-5, өдөртөө 14-19 градус, Алтайн өвөр нутаг, Олон нууруудын хөндийгөөр шөнөдөө 10-15 градус, өдөртөө 25-30 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10, өдөртөө 19-24 градус дулаан байна.

Энэ сард орох хур борооны хэмжээ нь Увсын ихэнх нутаг, Баян-Өлгий, Ховдын хойд, Говь-Алтайн баруун хойд болон зүүн өмнөд, Завханы баруун өмнөд, Баянхонгорын өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, Баянхонгорын хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр нутгийн зарим газраар, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн зүүн хагаст түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Дээрх бороо орох үеүдэд салхи зарим газраар түр зуур ширүүсч, зарим үед дуу цахилгааны өмнө 18-20 м/с хүрч болзошгүй.

**Төвийн нутаг.** The central region. Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 14-19 градус дулаан байх бөгөөд Хөвсгөлийн уулархаг нутаг, Булганы зүүн, Сэлэнгийн баруун, Өвөрхангайн өмнөд хэсэг, Төв аймгийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас 1.5 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхээр сэрүүсч Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус дулаан, хөрсний гадарга дээр сулхан цочир хүйтэрнэ, өдөртөө 12-17 градус дулаан байна. Хоёрдугаар арав хоногийн дунд үе болон эцсээр уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус, өдөртөө 12-17 градус, бусад нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 17-22 градус дулаан байна. Бусад хугацаанд Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 16-21 градус, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус, өдөртөө 21-26 градус дулаан байх бөгөөд ялангуяа хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр Орхон-Сэлэнгийн хөндийгөөр өдөртөө 30-35 градус, бусад нутгаар 25-30 градус хүрч халах төлөвтэй.

Энэ сард орох хур борооны хэмжээ нь Хөвсгөл, Сэлэнгийн баруун хойд хэсгээр олон жилийн дунджаас бага, Хөвсгөлийн зүүн өмнөд, Төв аймгийн зүүн хэсэг, Архангайн ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).

Нэг, хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар бороо, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр ихэнх нутгаар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай.

Дээрх бороо орох үеүдэд салхи зарим газраар түр зуур 16-18 м/с хүртэл ширүүсч болзошгүй.

**Зүүн зүгийн нутаг.** The eastern region. Агаарын температурын сарын дундаж нь 14-19 градус дулаан буюу Хэнтийн өмнөд, Дорнодын хойд, Сүхбаатарын баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас 1-1.5 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).



Нэгдүгээр арав хоногийн эхээр Хэнтий, Дорнодын хойд хэсгээр шөнөдөө 3 градус дулаанаас 2 градус хүйтэн, цочир хүйтэрнэ, өдөртөө 10-15 градус, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус, өдөртөө 15-20 градус дулаан байна. Хоёрдугаар арав хоногийн дунд үеэр Хэнтийн уулархаг нутгаар 1-6 градус, өдөртөө 14-19 градус, бусад нутгаар шөнөдөө 6-11 градус, өдөртөө 21-26 градус дулаан байна. Бусад хугацаанд Хэнтийн уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус, өдөртөө 21-26 градус, бусад нутгаар шөнөдөө 9-14 градус, өдөртөө 24-29 градус дулаан байх бөгөөд ялангуяа хоёрдугаар арав хоногийн эхэн болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар 28-33 градус хүрч хална.

Энэ сард орох хур борооны хэмжээ нь Хэнтийн өмнөд, Сүхбаатарын баруун хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Дорнодын хойд болон зүүн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар, дунд үеэр нутгийн баруун хэсгээр бороо орно, гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Дээрх бороо орох үеүдэд салхи зарим газраар түр зуур ширүүснэ, ялангуяа нэг, хоёр, гуравдугаар арав хоногийн эхэн ба нэгдүгээр арав хоногийн сүүлчээр түр зуур 16-18 м/с, зарим үед 24 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.

**Говийн нутаг.** The gobian region. Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 18-23 градус дулаан байх бөгөөд бүх нутгаар олон жилийн дунджаас 1.5 градусаар дулаан байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр сэрүүсч ихэнх нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 19-24 градус дулаан байна. Хоёрдугаар арав хоногийн эцсээр өмнөх үеэсээ бага зэрэг сэрүүсч шөнөдөө 8-13 градус, өдөртөө 21-26 градус дулаан байна. Бусад хугацаанд бүх нутгаар шөнөдөө 12-17 градус, өдөртөө 24-29 градус дулаан байх бөгөөд ялангуяа хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеэр 31-36 градус хүрч халах төлөвтэй.

Энэ сард орох хур борооны хэмжээ нь Дундговийн зүүн хэсэг, Говьсүмбэр, Дорноговийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу, Өмнөговийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон эцсээр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар бороо, гуравдугаар арав хоногийн эхэн болон эцсээр нутгийн хойд хэсгээр түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Бороо хур орох үеүдэд салхи зарим газраар түр зуур ширүүсэх бөгөөд зарим үед түр зуур 20-24 м/с хүртэл ширүүсч болзошгүй.

*\*\* - Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэн*